

Тойм ба үндэслэл

<p>Үзүүлэлт</p>	<p>11. Соёлын салбарын бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнд СББӨ-ийн олон талт байдал, түүнийг хамгаалахын ач холбогдлыг тусгаж, хэрэгжүүлдэг эсэх.</p>	
<p>Үнэлгээний хүчин зүйлүүд</p>	<p>Энэхүү үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайланг үндэсний түвшний гурван хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг:</p>	
	<p>11.1 СББӨ болон түүний хамгаалалтуудыг нэгтгэж, олон талт байдлыг тусгасан соёлын бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнүүд шинээр үүссэн эсвэл шинэчлэгдсэн бөгөөд одоогоор хэрэгжсээр байна.</p>	<p>13 Зүйл(а) OD 153(b)(i), OD 171(d)</p>
	<p>11.2 СББӨ-ийг хамгаалах үндэсний эсвэл дэд үндэсний стратеги ба/эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, шинэчлэн найруулж, түүн дээр тусгагдсан эсэхээс үл хамааран тодорхой элементүүдийн хамгаалалтын төлөвлөгөөг оруулан хэрэгжүүлж байна.</p>	<p>OD 1, OD 2</p>
	<p>11.3 СББӨ-ийн элементүүдийг хамгаалахад зориулсан төрийн санхүүгийн болон/эсвэл техникийн дэмжлэгийг соёл, өвийг бүхэлд нь дэмжихтэй уялдуулан эрх тэгш үндсэн дээр олгодог бөгөөд үүний зэрэгцээ дараахь зүйлд яаралтай хамгаалалтанд авах шаардлагатай хэмээн үзсэн хүмүүсийн нэн тэргүүнд авч үздэг.</p>	
	<p>11.4 СББӨ-ийг нэгтгэсэн соёлын бодлого ба/эсвэл хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ, түүнийг хамгаалах арга хэмжээнүүд нь олон нийт, бүлгүүд, хувь хүмүүсийн идэвхтэй оролцоогоор таниулагддаг.</p>	<p>Зүйл 15</p>

**ТХЗ болон
бусад
үзүүлэлтүүд
тэй
холбогдох
нь**

Тогтвортой хөгжлийн зорилтууд: Хэрэв соёлыг тогтвортой хөгжлийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны хэмжүүрийг идэвхжүүлэгч гэж хүлээн зөвшөөрвөл соёлын бодлого нь олон төрлийн ТХЗ-д нөлөөлж чадна гэсэн үг юм. Энэ хүрээнд СББӨ-ийн хамгаалалт нь тогтвортой хөдөө аж ахуй (ТХЗ 2), эрүүл мэнд, сайн сайхан байдал (ТХЗ 3), тогтвортой усны хэрэглээ (ТХЗ 6), биологийн олон янз байдал (ТХЗ 15) болон бусадтай холбоотой ТХЗ-д хувь нэмрээ оруулж чадна гэсэн үг юм. Гэсэн хэдий ч, тус үзүүлэлт нь ТХЗ-ын 16.7 зорилт буюу "бүх түвшинд хоорондын харилцаа сайтай, хүртээмжтэй, хүн бүрийн оролцоог дэмжсэн, төлөөллийн шийдвэр гаргах боломжийг хангах", мөн тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа холбоог сайжруулахыг уриалсан ТХЗ-ын зорилт 17.14-ийг тус тус тусгайлан дэмжиж байна гэж ойлгож болно. Тэгэхээр бүхий л үзүүлэлтүүдийн нэгэн адил энэ нь ТХЗ-ын 11.4 зорилт болох "Дэлхийн соёл болон байгалийн өвийг хамгаалах, түүнийг хамгаалах хүчин чармайлтыг бэхжүүлэх" зорилт шууд хамаарсан байна..

Бусад үзүүлэлтүүдийн хамаарал: Бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээг авч үзсэн нэмэлт дөрвөн үзүүлэлт байдаг (11-14). Дурьдагсан энэхүү үзүүлэлт 11 нь соёлын салбарт чиглэдэг; үзүүлэлт 12 нь анхаарлаа боловсролын салбар луу чиглүүлдэг; харин 13-р үзүүлэлт нь тогтвортой хөгжлийн бусад бүх салбарт хамаардаг байна. Эдгээрийн дөрөв дэх үзүүлэлт болох 14-р үзүүлэлт нь хөндлөн шинж чанартай бөгөөд эдгээр бүх салбаруудын бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээс нь уламжлалт эрх, дадлагууд, илэрхийллийг хэр зэрэг хүндэтгэж байгаа эсэхэд анхаардаг. Энэхүү үзүүлэлтийн гол чиглэл нь соёлын бодлогод чиглэж байгаа ч соёлын байгууллагууд, тэдгээрийн боловсон хүчин, хөтөлбөр, үйл ажиллагаа нь 1-3, 7-10, 15-25-р үзүүлэлтүүдийн субъект юм. Үзүүлэлт 10 нь салбар хоорондын бодлого боловсруулахад судалгаа, баримт бичгийг хэрхэн ашиглаж байгааг онцгойлон анхаарч үздэг бол 19-р үзүүлэлт нь бодлого, хөтөлбөрөөр дамжуулан дадлагажигч, өвлөн уламжлагч нар хэрхэн хүлээн зөвшөөрөгдөж байгааг харуулдаг.

<p>Үйл ажиллагааны үндэслэл</p>	<p>13(а) зүйлд оролцогч улсуудыг “биет бус соёлын өвийн нийгэм дэх үйл ажиллагааг дэмжих, уг өвийг хамгаалах асуудлыг төлөвлөлтийн хөтөлбөрт тусгахад чиглэгдсэн ерөнхий бодлого хэрэгжүүлэхийг” дэмжиж, тухайн бодлого боловсруулах үндсэн чиглэл, төлөвлөлтийн голлох хэсэг нь ерөнхийдөө соёлын салбар байх магадлалтай байдаг. Тэр бодлого, төлөвлөгөө нь хэр хэмжээнд эсвэл хэр бодитоор хэрэгжиж байгаа эсэх нь чухал. Эдгээр нь СББӨ-ийг соёлын томоохон бодлогод нэгтгэх ерөнхий арга хэмжээ (Үнэлгээний хүчин зүйл 11.1) эсвэл СББӨ-ийн ерөнхий эсвэл тусгай элементүүдийг (Үнэлгээний хүчин зүйл 11.2) хамгаалах стратеги эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөөний хэлбэрийг хэрэгжүүл болно. Тодорхой элементүүдэд анхаарлаа төвлөрүүлжс үнэлгээний хүчин зүйл 11.3-т бичигдсэн эсэхээс үл хамааран, СББӨ-ийг хамгаалахад улс орнуудыг санхүүгийн болон/эсвэл техникийн дэмжлэг үзүүлэхийг хөхүүлэн дэмждэг. Ингэхдээ бүртгэл эсвэл бусад аргаар яаралтай хамгаалах шаардлагатай гэж тодорхойлсон элементүүдэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Эцэст нь, үнэлгээний хүчин зүйл 11.4 нь 15 дугаар зүйлд заасны дагуу олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс СББӨ-ийн хамгаалалт, менежментэд хэр зэрэг идэвхтэй оролцож байгааг харж болно.</p>
<p>Гол нэр томъёо</p>	<ul style="list-style-type: none"> • Бодлогууд • Хууль эрх зүйн арга хэмжээ • Захиргааны арга хэмжээ • Олон талт байдал (СББӨ болон түүний дадлагажигчид) • СББӨ-ийн элементүүд • Бичигдсэн (тусгагдсан эсэхээс үл хамааран) • Оролцоо эсвэл оролцож буй байдал • Олон нийт, бүлгүүд, зарим тохиолдолд хувь хүмүүс

Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар

Хяналтын ашиг тус	<p>Бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээг хянах нь тэдгээрийн үр нөлөөг харуулах чухал хэрэгсэл юм. одлого нь бодитой, хэрэгжих боломжтой эсэх, эсвэл өөрчлөх, өөрчлөх шаардлагатай эсэхийг хэрэгжүүлэлтийн бодит туршлагаас харж болно.Тодорхой стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт тавих нь чанартай туршлагыг тодорхойлоход эсвэл үр дүнгүй, засч залруулах эсвэл орхих шаардлагатай хүчин чармайлтыг илрүүлэхэд тус болно. Энэ нь бодлогын засч залруулах шаардлагатай цоорхойг бас харуулж чадна. СББӨ-ийн зохицуулалтад олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс байж болох хамгийн өргөн хүрээнд оролцоход саад болж буй саад бэрхшээл байгаа эсэхийг бодлого боловсруулах үйл явцад хяналт тавих нь илрүүлж, тэдгээрийг даван туулах арга замыг зааж өгдөг. Дэлхийн түвшинд хяналт тавих нь оролцогч талуудын бодлогын хүрээнд Конвенц нь хэрхэн чанартайгаар нэгдэж байгааг хянаж, интеграцлалын сайн загваруудыг тодорхойлох боломжтой.</p>
--------------------------	---

Мэдээллийн эх сурвалж, цуглуулга

Соёлын яам нь ихэвчлэн соёлын салбарын бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээг боловсруулах байгууллага юм. Ийм арга хэмжээнд соёлын өвийн тухай үндэсний хуулиас авхуулаад (эсвэл соёлын биет бус өвийн тухай) янз бүрийн захиргааны зохицуулалт хүртэл багтаж болно. Бодлого нь ерөнхийдөө ийм хууль тогтоомжид нийцүүлэн, төлөвлөлтийн мөчлөгийн дагуу (жишээлбэл, таван жилийн төлөвлөгөө эсвэл арван жилийн төлөвлөгөө) боловсруулагддаг. СББӨ-ийг хамгаалахад чиглэсэн үндэсний стратеги эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний доторх тодорхой элементүүдийн төлөвлөгөө нь төв яамны шууд хяналт дор байдаггүй байх ч боломжтой. Хэрэв тухайн улс зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулах механизмтай бол (Үнэлгээний хүчин зүйл 1.3-ыг харна уу) тухайн байгууллага нь хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг мөн хянаж болно. Хамгаалах зорилгоор төрийн санхүүгийн болон/эсвэл техникийн дэмжлэг үзүүлж байгаа бол бүртгэлийг санхүүжүүлэгч байгууллага (байгууллагууд) хөтөлнө. Бодлогын үйл явцад олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс хэр идэвхтэй оролцож байгаа нь тодорхой удирдамж эсвэл тиймэрхүү оролцооны шаардлагуудаар зохицуулагдаж болох ба, бодлогын үйл явцад илүү чанарын ажиглалт хийх шаардлагатай ч байж болно.

Боломжит мэдээллийн эх сурвалжууд

- Албан ёсны сонин/сэтгүүл эсвэл хууль, эрх зүйн зохицуулалтын эмхэтгэл
- Соёлын яам эсвэл хууль тогтоох байгууллагын бодлогын баримт бичиг
- Соёлын яам ба/эсвэл СББӨ-ийн хамгаалалтыг дэмждэг бусад санхүүжилтийн агентлагуудын төсөв, ажлын төлөвлөгөө
- Яаралтай хамгаалалтын жагсаалт эсвэл төлөөлөгчийн жагсаалтад оруулахыг санал болгож буй элементүүдийн нэр дэвшүүлэх файлууд
- Тус файлуудын нэг хэсэг болох хамгаалалтын төлөвлөгөө шаардлагатай бол улсын түвшний жагсаалт эсвэл бүртгэлд оруулахаар санал болгож буй элементүүдийн нэр дэвшүүлэх файлууд
- Бодлогын үйл явцад тэдний оролцоог үнэлэхийн тулд олон нийт, бүлгүүд, хувь хүмүүстэй хийсэн судалгаанууд эсвэл асуулгууд